



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/53

Хажуу шинэ-Ус

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн В, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 01/767 дугаар тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны хагас жилийн түүвэр мал тооллогын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Даваасүрэн (Засаг даргын орлогчийг түр хавсран гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Н.Болор-Эрдэнэ (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: Б.Гүнсэнтүг (1 дүгээр багийн Засаг дарга)

Г.Батчулуун (2 дугаар багийн Засаг дарга)

Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)

Д.Сарангэрэл (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Э.Уранбилэг (Сан хариуцсан нягтлан бодогч)

2.Хагас жилийн түүвэр мал тооллогын ажлыг 05 дугаар сарын 30-аас 06 дугаар сарын 07-ний дотор сонгогдсон өрхүүдэд явуулж нүд үзэн тоолж, тооллогын ажлыг чанартай үр дүнтэй явуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3.Мал тооллогын мэдээллийг программд шивж нэгдсэн дүнг аймгийн статистикийн хэлтэст 06 дугаар сарын 09-ны дотор тушаахыг Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА Т.АРИУНАА

